

ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/201/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал.....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/138
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 53,993.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг төлөвлөж, 98.4 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ төгрөгөөр / Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	263,342,255.41	360,698,822.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	53,993,840.19
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	53,993,840.19
31210	Төгрөг	-	53,993,840.19
31211	Төрийн сангийн харилцах	-	53,993,840.19
33	АВЛАГА	-	10,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	10,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	263,342,255.41	296,704,982.41
35100	Түүхий эд материал	5,318,281.00	3,381,007.00
35130	Эм боох материал	5,318,281.00	3,381,007.00
35400	Хангамжийн материал	258,023,974.41	293,323,975.41
35410	Бичиг хэргийн материал	2,787,580.00	987,100.00
35420	Аж ахуйн материал	784,150.00	539,600.00
35450	Барилгын засварын материал	2,300,200.00	2,148,590.00
35470	Бусад хангамжийн материал	252,152,044.41	289,648,685.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	502,013,100.45	519,850,822.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	502,013,100.45	519,850,822.60
39200	Биет хөрөнгө	255,560,922.40	275,553,355.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	312,905,165.15	312,905,165.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(270,125,157.35)	(273,734,572.18)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	144,024,601.25	180,540,206.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,759,367.39)	(40,538,953.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,303,700.58	79,283,640.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,365,445.76)	(21,268,926.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,801,297.00	6,801,297.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,006,711.88)	(5,172,569.00)
39217	Ном	31,782,840.80	36,738,068.80
39300	Биет бус хөрөнгө	246,452,178.05	244,297,466.81
39301	Програм хангамж	10,773,556.00	10,773,556.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,053,877.95)	(4,208,589.19)
39303	Бусад биет бус хөрөнгө	237,732,500.00	237,732,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	765,355,355.86	880,549,645.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	293,110.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	293,110.00
41300	Өглөг	-	293,110.00
41360	Бусад өглөг	-	293,110.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	293,110.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	765,355,355.86	880,256,535.20
51	Засгийн газрын хувь оролцоо	765,355,355.86	880,256,535.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	641,784,144.72	-
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	641,784,144.72	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	641,784,144.72
51200	Хуримтлагдсан үр дүн	78,404,701.54	193,305,880.88
51210	Өмнөх үеийн үр дүн	(44,877,393.18)	78,404,701.54
51220	Тайлант үеийн үр дүн	123,282,094.72	114,901,179.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,166,509.60	45,166,509.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	765,355,355.86	880,549,645.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,318,266,915.00	1,766,162,344.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,525,476.09	94,008,444.50
120	Нийтлэг татварын бус орлого	88,525,476.09	90,785,244.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,191,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,656,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	535,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	69,116,007.48	45,591,148.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,409,468.61	43,002,996.50
122	Тусламжийн орлого	-	3,223,200.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	3,223,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,229,741,438.91	1,672,153,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,094,892,400.00	138,956,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	138,956,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,094,892,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,111,038.91	12,959,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,450,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,626,038.91	11,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	1,459,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,738,000.00	1,520,237,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,738,000.00	1,520,237,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,181,656,681.91	1,651,261,165.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,656,681.91	1,651,261,165.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,134,470,560.48	1,559,657,519.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837,959,712.36	1,153,073,182.42
210101	Үндсэн цалин	632,144,099.76	814,374,133.86
210102	Нэмэгдэл	156,741,824.60	238,419,948.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	29,618,916.78
210104	Урамшуулал	49,073,788.00	70,660,183.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,996,485.39	145,174,062.39
210201	Тэтгэврийн даатгал	78,478,430.05	98,636,285.42
210202	Тэтгэмжийн даатгал	8,432,756.55	11,843,986.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,714,371.87	9,251,481.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,670,084.46	2,312,845.43
210205	Эрүүл мэндийн даатгал	16,700,842.46	23,129,463.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,080,789.73	90,944,239.79
210301	Гэрэл, цахилгаан	2,857,520.00	3,740,347.25
210302	Түлш, халаалт	78,592,111.00	78,552,111.20
210303	Цэвэр, бохир ус	4,631,158.73	8,651,781.34
2104	Хангамж, бараа материалын зардал	14,389,269.00	18,770,658.00
210401	Бичиг хэрэг	3,343,635.00	2,205,550.00
210402	Тээвэр, шатахуун	598,000.00	463,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	359,992.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,644,788.00	-

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,561,540.00	6,024,650.00
210408	Бараа материал акталсны зардал	4,881,314.00	10,077,358.00
2105	Нормативт зардал	907,448.00	2,199,124.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	907,448.00	2,199,124.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,762,510.00	28,364,310.00
210604	Урсгал засвар	34,762,510.00	28,364,310.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	-
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,990,800.00	13,359,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,270,800.00	3,116,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,243,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,303,546.00	107,772,543.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,780,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,087,771.25	20,379,277.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,215,774.75	70,612,305.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,186,121.43	91,603,645.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,299,400.00	91,473,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,768,800.00	91,473,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,530,600.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	198,961.18	130,645.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,810.27	130,645.21
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,150.91	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,687,760.25	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,687,760.25	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	136,610,233.09	114,901,179.34
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,328,138.37	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	13,328,138.37	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	123,282,094.72	114,901,179.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН / төгрөгөөр /
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,229,741,438.91	1,674,345,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,191,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,191,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,191,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,656,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	535,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,229,741,438.91	1,672,153,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,094,892,400.00	1,520,237,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,520,237,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,094,892,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,111,038.91	12,959,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,450,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,626,038.91	11,500,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	1,459,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,738,000.00	138,956,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,738,000.00	138,956,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,179,537,638.91	1,577,492,279.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,179,537,638.91	1,577,492,279.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,132,351,517.48	1,485,888,634.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837,959,712.36	1,163,073,182.42
210101	Үндсэн цалин	581,981,922.80	824,374,133.86
210102	Нэмэгдэл	206,653,048.56	238,419,948.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	29,618,916.78
210104	Урамшуулал	49,324,741.00	70,660,183.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,996,485.39	145,174,062.39
210201	Тэтгэврийн даатгал	78,948,128.07	98,636,285.42
210202	Тэтгэмжийн даатгал	8,262,077.08	11,843,986.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,609,651.45	9,251,481.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,652,425.63	2,312,845.43
210205	Эрүүл мэндийн даатгал	16,524,203.16	23,129,463.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,080,789.73	90,651,129.79
210301	Гэрэл, цахилгаан	2,857,520.00	3,447,237.25
210302	Түлш, халаалт	78,592,111.00	78,552,111.20
210303	Цэвэр, бохир ус	4,631,158.73	8,651,781.34
2104	Хангамж, бараа материалын зардал	28,458,630.00	1,459,900.00
210401	Бичиг хэрэг	3,046,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	214,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	359,992.00	-
210404	Ном, хэвлэл	-	1,459,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,223,888.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,614,750.00	-
2105	Нормативт зардал	989,400.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	989,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,460,400.00	22,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	-
210604	Урсгал засвар	29,460,400.00	22,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	-
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,763,800.00	11,899,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,043,800.00	1,656,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,243,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,562,300.00	51,630,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00	26,066,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,812,300.00	25,564,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,186,121.43	91,603,645.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,299,400.00	91,473,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,768,800.00	91,473,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,530,600.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	198,961.18	130,645.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,810.27	130,645.21
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,150.91	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,687,760.25	-

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,687,760.25	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	50,203,800.00	96,852,720.19
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	50,203,800.00	42,858,880.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,203,800.00	42,858,880.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,203,800.00	42,858,880.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,203,800.00	42,858,880.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(50,203,800.00)	(42,858,880.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	53,993,840.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	53,993,840.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,784,144.72	45,166,509.60	(44,877,393.18)	642,073,261.14
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	641,784,144.72	45,166,509.60	(44,877,393.18)	642,073,261.14
Тайлант үеийн үр дүн	-	-	123,282,094.72	123,282,094.72
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,784,144.72	45,166,509.60	78,404,701.54	765,355,355.86
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	641,784,144.72	45,166,509.60	78,404,701.54	765,355,355.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	641,784,144.72	45,166,509.60	78,404,701.54	765,355,355.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	114,901,179.34	114,901,179.34
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	641,784,144.72	45,166,509.60	193,305,880.88	880,256,535.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,522,428,200.00	1,468,434,359.81	53,993,840.19	96.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,522,428,200.00	1,468,434,359.81	53,993,840.19	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,429,390,900.00	1,376,961,359.81	52,429,540.19	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,186,144,400.00	1,139,798,057.42	46,346,342.58	96.1
210101	Үндсэн цалин	931,997,700.00	804,057,714.86	127,939,985.14	86.3
210102	Нэмэгдэл	223,729,800.00	237,261,282.61	(13,531,482.61)	106.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	29,618,916.78	(29,618,916.78)	
210104	Урамшуулал	30,416,900.00	68,860,143.17	(38,443,243.17)	226.4

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авъяас сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,268,000.00	142,274,062.39	5,993,937.61	96.0
210201	Тэтгэврийн даатгал	100,822,200.00	96,664,285.42	4,157,914.58	95.9
210202	Тэтгэмжийн даатгал	11,861,500.00	11,611,986.19	249,513.81	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,489,100.00	9,065,881.47	423,218.53	95.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,372,300.00	2,266,445.43	105,854.57	95.5
210205	Эрүүл мэндийн даатгал	23,722,900.00	22,665,463.88	1,057,436.12	95.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,903,600.00	11,899,500.00	4,100.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,656,100.00	1,656,100.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,247,500.00	10,243,400.00	4,100.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,074,900.00	82,989,740.00	85,160.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,703,700.00	67,625,140.00	78,560.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,371,200.00	15,364,600.00	6,600.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,037,300.00	91,473,000.00	1,564,300.00	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,037,300.00	91,473,000.00	1,564,300.00	98.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	93,037,300.00	91,473,000.00	1,564,300.00	98.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,522,428,200.00	1,522,428,200.00	-	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,520,237,100.00	1,520,237,100.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,520,237,100.00	1,520,237,100.00	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,191,100.00	2,191,100.00	-	100.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,656,100.00	1,656,100.00	-	100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	535,000.00	535,000.00	-	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	53,993,840.19	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	71.00	71.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	56.00	56.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.0

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,956,900.00	138,826,254.79	130,645.21	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,956,900.00	138,826,254.79	130,645.21	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,956,900.00	138,826,254.79	130,645.21	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,275,300.00	23,275,125.00	175.00	100.0
210101	Үндсэн цалин	20,316,500.00	20,316,419.00	81.00	100.0
210102	Нэмэгдэл	1,158,700.00	1,158,666.00	34.00	100.0
210104	Урамшуулал	1,800,100.00	1,800,040.00	60.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,030,000.00	2,900,000.00	130,000.00	95.7
210201	Тэтгэврийн даатгал	2,102,000.00	1,972,000.00	130,000.00	93.8
210202	Тэтгэмжийн даатгал	232,000.00	232,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	185,600.00	185,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	46,400.00	46,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	464,000.00	464,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,651,600.00	90,651,129.79	470.21	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,830,000.00	3,447,237.25	382,762.75	90.0
210302	Түлш, халаалт	78,551,600.00	78,552,111.20	(511.20)	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,270,000.00	8,651,781.34	(381,781.34)	104.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,000,000.00	22,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	22,000,000.00	22,000,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,956,900.00	138,826,254.79	130,645.21	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	138,956,900.00	138,826,254.79	130,645.21	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	138,956,900.00	138,826,254.79	130,645.21	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,959,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,959,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,959,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,459,900.00
210404	Ном, хэвлэл	1,459,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,500,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,959,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,959,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,459,900.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус сургууль нь 2022 онд “Урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын үйлчилгээ, хүүхэд бүрийг хөгжүүлэх чиглэлээр аймагтаа манлайлагч, хүүхдэд аюулгүй ээлтэй сургууль болох стратегийн зорилгыг баримтлан ажиллаж байна.” гэсэн зорилт тавьж ажиллажээ.

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг төлөвлөж, 98.4 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж,

- хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал " Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу 2021 онд байгууллагын дотоод хяналтын багийг байгуулсан байна.

Дотоод хяналтын багаас нь 2022 оны дотоод хяналтын төлөвлөгөөг батлуулан орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдлийн үнэлгээ хийх, үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсгүүдийг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115,194.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3
Мөнгөн хөрөнгө		53,993.8	53,993.8
Авлага		10,000.0	10,000.0
Бараа материал	263,342.3	296,705.0	33,362.7
Үндсэн хөрөнгө	502,013.1	519,850.8	17,837.7
Нийт хөрөнгө	765,355.4	880,549.6	115,194.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.0	293.1	293.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	765,355.4	880,256.5	114,901.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн	765,355.4	880,549.6	115,194.3

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмч дансдууд өмнөх оноос нэмэгдэж, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 53,993.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

2. Авлага дансны үлдэгдэл 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын ахмадын санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг авлагаар тусгасантай холбоотой.
3. Бараа материал дансны үлдэгдэл 33,362.7 мянган төгрөгөөр нэмэгдэхэд БШУЯ-аас хөгжмийн зэмсэг, сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн нь нөлөөлсөн.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,837.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь батлагдсан төсвийн хүрээнд 42,858.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглагдах 41,335.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэ тогтоож орлогод авсан, 10,085.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан болон тайлант үеийн элэгдлийн зардлаас шалтгаалсан өөрчлөлт байна.
5. Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 114,901.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

6. 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих зардлын дүнг 1,384,585.4 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

УИХ-аар 2022 оны төсвийг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэхээр болсонтой холбоотойгоор байгууллагын төлөвлөж хүргүүлсэн дүнг 281,799.9 мянган төгрөгөөр бууруулан 1,102,785.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулснаар анхны баталсан төсвийг 417,451.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,522,428.2 мянган төгрөгөөр, үүнээс 1,520,237.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 2,191.1 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийг Мөрөн сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 155,661.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлаар нэмэгдүүлэн баталсантай холбоотой.

Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж, 17,487.5 мянган төгрөгөөр бууруулан, 138,173.6 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн А/429 дүгээр захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 783.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлснээр орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын нийт дүн 138,956.9 мянган төгрөг болсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,863,547.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 544,238.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 2,407,785.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 8,237.9 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,337.9 мянган төгрөгийн төвлөрүүлж, 89.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 99.2 хувьтай, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 4,197.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн.

Улсын төсвөөс санхүүжих зардал 97.9 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 39,010.5 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,727.0	4,726.6	0.4	100.0
2	80312-Сургалт семинар	2,363.5	0.0	2,363.5	0.0
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	5,436.1	3,502.0	1,934.1	64.4
4	81801-Үдийн цай хөтөлбөр	81,412.7	81,406.3	6.4	100.0
5	81806-Дотуур байрны үйлчилгээ	264,667.8	256,001.0	8,666.8	96.7
6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	55,445.0	55,437.0	8.0	100.0
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	10,635.8	10,580.0	55.8	99.5
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,286,319.3	1,272,979.2	13,340.1	99.0
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	152,539.9	139,904.5	12,635.4	91.7
Дүн		1,863,547.1	1,824,536.6	39,010.5	97.9
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	482,363.8	482,363.7	0.1	100.0
2	80112-Нийтлэг үйлчилгээ	61,874.7	57,677.7	4,197.0	93.2
Дүн		544,238.5	540,041.4	4,197.1	99.2
Нийт дүн		2,407,785.6	2,364,578.0	43,207.6	98.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт төсвийн дансаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,257.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,181,656.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23,633.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 заалтад заасан Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулах заалтаас бусад заалтыг хэрэгжүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй асуудалд зөвлөмж хүргүүлсэн ба тайлангийн 4.4.1 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 5

мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15,459.4 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалтад заасан “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан зардлын зориулалт, арга хэмжээ, нормативын дагуу төсвийг тооцон шинжлэхэд 300,102.9 мянган төгрөгийн санхүүжилтийн илүү тооцоо гарч байна. Энэ нь 2022 онд Засгийн газрын шийдвэрээр багш нарын болон үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр баталсан үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг улсын төсвөөс олгосонтой холбоотой боловч төсвийн төлөвлөлтийг сайжруулахад холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатайг харуулж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,663.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 10,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, нийцлийн аудиттай холбоотой 15459.4 мянган төгрөгийн алдаанд 1 зөвлөмж, төсвийн зарцуулалттай холбоотой 18,204.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Сургуулийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/62 дугаар тушаалаар 10,000.0 мянган төгрөг ахмадын сан байгуулж, сургуулийн ахмадын холбооны “Сургаал арвижих” төрийн бус байгууллагын дансанд шилжүүлж цалингийн зардлаар бүртгэснийг төрийн санд ахмадын сан нээлгэн төвлөрүүлж, авлагаар бүртгэн залруулсан.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудалд дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

Илрүүлэлт:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Тус байгууллага нь төсөвт батлагдаагүй зардал 18,204.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг ажиллагсдад олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод журам, хамтын гэрээнд тусгагдсан зардлыг төсвийн төсөлд тусган, дээд шатны байгууллагад хүргүүлэх.

Илрүүлэлт:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгаж үзэхэд 15,459.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг мөрдөж, мэдээллийг тухай бүр байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалингийн зардлаас "Сургаал арвижих" ТББ уруу ахмадын сангийн мөнгө шилжүүлсэн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
Дүн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь төсөвт батлагдаагүй зардал унаа, хоолны хөнгөлөлтийг ажиллагсдад олгосон байна	1	18,204.0					1	18,204.0				
Дүн	1	18,204.0					1	18,204.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй	1	15,459.4					1	15,459.4
Дүн	1	15,459.4					1	15,459.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	15,459.4					1	15,459.4